



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/400

Есөнбулаг сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын Зөвлөлийн 2026 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024–2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон бусад бодлогын баримт бичиг, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэд, төрийн албан хаагчид, төлөөлөгчид, сумдын төрийн байгууллагын ажилтан, албан хаагчид, хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, салбарын хөгжлийн төлөвлөлттэй танилцуулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн шилдэг туршлага судлуулах арга хэмжээг зохион байгуулах ажлыг "Эй ди интернэшнл" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Насанбат)-д олгосугай.

2. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах 19.550.000 (арван есөн сая таван зуун тавин мянга) төгрөг-ийг орон нутгийн төсвийн урсгал зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Насанбат)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг ханган, арга хэмжээний ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, тайлагнан ажиллахыг аймгийн Засаг даргын Хэвлэлийн алба (Д.Баяраа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ



